



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/625

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “д”, 29.2, төсвийн тухай хуулийн 14.2.3, 65.1.1, аймгийн ИТХ-ын 2017 оны ээлжит 4 дүгээр хуралдааны 1 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт хамтын хэлэлцээрийн дагуу “Нийгмийн түншлэл-хамтын ажиллагаа-2017” сургалт зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах 2,5 сая төгрөгийг Засаг дарга данснаас зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч /Ц.Мөнхтуяа/-д зөвшөөрсүгэй.

2. “Нийгмийн түншлэл-хамтын ажиллагаа-2017” сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулалтын өндөр түвшинд хангаж, оролцогчдыг бүрэн хамруулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Ж.Ганболд/, аймгийн Ажил олгогч эздийн холбооны нарийн бичгийн дарга /Б.Базардамбуу/, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга /Ц.Ганболд/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА  Л.ГАНБОЛД

